



**ХЭНТИЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 20

Чингис хот

Өргөдөл хянан шалгах комисс  
байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.3-т заасны дагуу ТОГТООХ нь:

1. Өмнөдэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Баярмаагийн салбар зөвлөлд 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хандан гаргасан өргөдлийг хянан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Ж.Гантулга	-Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Лхагвахатан	-Салбар зөвлөлийн гишүүн, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Ч.Болормаа	-Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

2. Маргааныг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу 30 хоногийн дотор шударга, шуурхай шалган шийдвэрлэж, дүгнэлт гарган Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг комиссын дарга /Ж.Гантулга/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР